

НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ  
2014 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН  
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Тус алба нь иргэд, байгууллагаас хандан гаргасан өргөдөл гомдлыг дараах байдлаар хүлээн авч байна. Үүнд:

- бичгээр,
- амаар буюу биечлэн
- 7019-7019 дугаарын нээлттэй утсаар
- info@courtservice.mn цахим хаягаар

Ирүүлсэн өргөдөл гомдлыг [www.smartcity.mn](http://www.smartcity.mn) цахим хуудас буюу “Өргөдөл гомдлын нэгдсэн програм”-ыг ашиглан бүртгэж, дахин гомдол гаргахгүй байх, эцэслэн шийдвэрлэхээр гомдол гаргагчтэй биечлэн уулзаж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцыг танилцуулж байгаа бөгөөд шийдвэрлэх боломжтой өргөдлийн хариуг шууд биечлэн өгөх, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах шаардлагатай бол ажлын 5 хоног, шаардлагатай бол албаны даргаар сунгуулан 14 хоногт, хугацаа шаардлагатай бол хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн тухайгаа биечлэн болон бичгээр, цахим хаягаар хариу хүргүүлж байна. Энэ оны нэгдүгээр улирлын байдлаар албаны дарга болон дэд дарга нар 161 өргөдөл гомдол гаргагчтай биечлэн уулзаж, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн 7 өргөдөл гаргагчийн хариуг утсаар өгсөн байна.

Тус албанд гаргасан өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хурдыг 2014 оны 03 дугаар сарын 14-ны байдлаар харуулбал, хугацаандаа шийдвэрлэсэн 137 өргөдөл гомдол байна. Үүнээс, ажлын 5 хоногт 46 өргөдөл гомдол, 10 хоногт 42 өргөдөл гомдол, 15 хоногт 21 өргөдөл гомдол, 30 хоногт 28 өргөдөл гомдлыг шийдвэрлэн, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хурд 10 хоног, 5 цаг, 53 минут байна.


Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээ, мэдээллийн ил тод байдлыг бий болохын тулд албаны twitter, facebook олон нийтийн сүлжээ, [www.courtservice.mn](http://www.courtservice.mn) цахим хуудас, электрон самбарт тогтмол байршуулан, олон нийтэд хүргэж байна.

Өргөдөл гомдлыг нэг мөр эцэслэн шийдвэрлэхийн тулд гомдол гаргагчтай уулзан, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар танилцуулснаар давтан өргөдөл гомдол гаргагчийн тоог бууруулахаар ажиллаж байна.

СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР АЛБАНД  
ХАНДАН ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ТОО



СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР АЛБАНД  
ХАНДАН ГАРГАСАН ГОМДЛЫН ТОО



СҮҮЛИЙН 4 ЖИЛИЙН НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР АЛБАНД  
ХАНДАН ГАРГАСАН ХҮСЭЛТИЙН ТОО

